



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 809

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2023 оны 393 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Япон улс дахь "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв"-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 28 нэрийн, нийт 31,928,724.79 (гучин нэгэн сая есөн зуун хорин найман мянга долоон зуун хорин дөрвөн төгрөг далан есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 5,417,410.20 (таван сая дөрвөн зуун арван долоон мянга дөрвөн зуун арван төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007442
37-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
20.4 дугаар тогтоолын хавсралт

Япон улс дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв”-ийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яаманд
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Нийт хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Принтер	2020-12-31	1	2,723,155.20	2,723,155.20	544,631.04	2,178,524.16
2	Зееврийн компьютер	2020-12-31	1	2,541,391.20	2,541,391.20	508,278.24	2,033,112.96
3	Люминаторийн машин	2022-04-18	1	267,751.00	267,751.00	89,250.36	178,500.64
4	Агаар цэвэршүүлэгч	2022-04-21	1	294,379.80	294,379.80	98,126.64	196,253.16
5	Вэйб камер	2022-06-08	1	46,060.00	46,060.00	9,212.04	36,847.96
6	Канон	2022-12-26	1	4,281,750.00	4,281,750.00	856,350.00	3,425,400.00
7	Компьютер isus acer	2021-03-31	1	2,702,442.60	2,702,442.60	540,488.52	2,161,954.08
8	2ш суурин компьютер	2020-12-31	2	3,022,239.60	6,044,479.20	1,208,895.84	4,835,583.36
9	2ш компьютерийн дэлгэц	2020-12-31	2	357,469.20	714,938.40	142,987.68	571,950.72
10	2ш вэйб камер	2020-12-31	2	52,050.60	104,101.20	20,820.24	83,280.96
11	Тавиур бор	2022-04-11	1	452,667.00	452,667.00	45,266.76	407,400.24
12	Буйдан хар	2022-05-23	1	1,202,759.40	1,202,759.40	240,551.88	962,207.52
13	Ширээ шилэн хар	2022-05-23	1	312,780.00	312,780.00	62,556.00	250,224.00
14	Сэтгүүлийн тавиур	2022-09-28	1	259,877.95	259,877.95	51,975.60	207,902.35
15	Суурин утас	2020-12-31	1	145,962.00	145,962.00	14,596.20	131,365.80
16	Сейф	2020-12-31	1	256,397.40	256,397.40	25,639.80	230,757.60
17	Хөргөгч	2020-12-31	1	947,926.80	947,926.80	94,792.68	853,134.12
18	Богино долгионы халаагч	2020-12-31	1	180,387.00	180,387.00	18,038.76	162,348.24
19	Тоос сорогч	2020-12-31	1	457,439.40	457,439.40	45,744.00	411,695.40
20	Ус буцалгагч	2020-12-31	1	192,229.20	192,229.20	19,222.92	173,006.28

21	1ш цаас хэрчигч	2020-12-31	1	167,200.00	167,200.00	16,719.96	150,480.04
22	Хурлын ширээ 1ш	2020-12-31	1	1,361,250.00	1,361,250.00	136,125.00	1,225,125.00
23	Бичиг баримт хийх шүүгээ	2020-12-31	3	544,500.00	1,633,500.00	163,350.00	1,470,150.00
24	8ш сандал	2020-12-31	8	105,875.00	847,000.00	84,699.84	762,300.16
25	Принтерийн тавцан	2020-12-31	1	214,573.44	214,573.44	21,457.32	193,116.12
26	Офисс сандал 3ш	2020-12-31	3	236,740.40	710,221.20	71,022.24	639,198.96
27	Офисс ширээ 3ш	2020-12-31	1	2,680,761.20	2,680,761.20	268,076.16	2,412,685.04
28	Хаяг хэвлэгч	2020-12-31	1	185,344.20	185,344.20	18,534.48	166,809.72
	Нийт дүн		42		31,928,724.79 (гучин нэгэн сая есөн зуун хорин найман мянга долоон зуун хорин дөрвөн тегрэг далан есөн мөнгө)	5,417,410.20 (таван сая дөрвөн зуун арван долоон мянга дөрвөн зуун арван тегрэг хорин мөнгө)	26,511,314.59 (хорин зургаан сая таван зуун арван нэгэн мянга гурван зуун арван дөрвөн тегрэг тавин есөн мөнгө)